



НИЙСЛЭЛИЙН
СТАТИСТИКИЙН
ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2021 10 САР
СТАТИСТИКИЙН
ТАНИЛЦУУЛГА



www.ubstat.mn



www.facebook.com/StatisticUlaanbaatar



www.1212.mn



АГУУЛГА

Хуудасны
дугаар



НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ,
2017-2021 ОН

1



НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ,
ДҮҮРГЭЭР

2



ЭРҮҮЛ МЭНД

4



ЦАГ УУР, АГААРЫН ЧАНАР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ

9



ГЭМТ ХЭРЭГ

15



ТӨСӨВ

19



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

23



НИЙГМИЙН ДААТГАЛ

33



ГАЗАР ТАРИАЛАН

36



АЖ ҮЙЛДВЭР

38



БАРИЛГА

44



ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙ

49

Хүснэгт 1. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний 10 сард

Үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	2017	2018	2019	2020	2021
Шинээр төрсөн хүүхэд		хүн	↓ 31 566 ↓7.8	↑ 33 824 ↑7.1	↑ 34 260 ↑1.3	↓ 33 327 ↓2.8	↓ 30 885 ↓7.3
Халдварт өвчнөөр өвчлөгчид		хүн	↓ 22 941 ↓35.3	↓ 19 064 ↓116.9	↑ 20 172 ↑5.8	↓ 14 173 ↓29.7	↑ 227 706 ↑15**
Бүртгэгдсэн гэмт хэрэг		тоо	↑ 17 734 ↑16.2	↑ 22 422 ↑26.4	↓ 18 716 ↓16.5	↓ 13 399 ↓28.4	↓ 12 926 ↓3.5
Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт)		хувь	↑ 0.4 ↑1.6	↑ 1.2 ↑0.8	↓ -0.6 ↓1.8	↑ 0.5 ↑1.1	↓ 0.0 ↓0.5
Гадаад валютын нэрлэсэн ханш (сарын дундаж)	Доллар (АНУ)	төгрөг	↑ 2 459 ↑6.5	↑ 2 564 ↑4.3	↑ 2 678 ↑4.4	↑ 2 854 ↑6.6	↓ 2 849 ↓0.2
	Юань (БНХАУ)	төгрөг	↑ 371 ↑8.2	↓ 370 ↓0.3	↑ 377 ↑1.9	↑ 424 ↑12.5	↑ 444 ↑4.7
	Рубль (ОХУ)	төгрөг	↑ 43 ↑16.2	↓ 39 ↓9.3	↑ 42 ↑7.7	↓ 37 ↓11.9	↑ 40 ↑8.1
Нийслэлийн төсвийн орлого		тэрбум төгрөг	↓ 552.8 ↓19.1	↑ 690.6 ↑24.9	↑ 745.8 ↑8.0	↓ 678.9 ↓9.0	↑ 921.7 ↑35.7
Нийслэлийн төсвийн зарлага		тэрбум төгрөг	↓ 751.5 ↓1.4	↑ 973.0 ↑29.5	↑ 1 008.5 ↑3.6	↓ 987.2 ↓2.1	↓ 959.4 ↓2.8
Агаарын дундаж температур		°C	0.7	2.8	0.9	-0.6	1.6

Тайлбар: Өмнөх онтой харьцуулсан

  Эерэг хандлага, өөрчлөлт
  Сөрөг хандлага, өөрчлөлт

Хүснэгт 2. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих Нэгж	2020 I-X					2021 I-X				
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	317	Баянгол	7 757	Налайх	56	323	Баянгол	7 951	Налайх	57
			Чингэлтэй	1 716	Багануур	47		Чингэлтэй	1 712	Багануур	48
			Сүхбаатар	706	Багахангай	30		Сүхбаатар	700	Багахангай	33
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	12	Багахангай	26	Багануур	8	11	Налайх	18	Баянзүрх	8
			Сонгинохайрхан	12	Хан-Уул	6		Сонгинохайрхан	12	Хан-Уул	7
			Налайх	11	Сүхбаатар	4		Баянгол	12	Багахангай	-
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	97	Налайх	91	Сүхбаатар	60	1 534	Хан-Уул	1 314	Багануур	820
			Багануур	81	Хан-Уул	56		Баянзүрх	1 270	Сонгинохайрхан	780
			Баянзүрх	84	Багахангай	21		Баянгол	1 178	Багахангай	619
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	69	Хан-Уул	62	Багануур	11	96	Чингэлтэй	96	Налайх	17
			Чингэлтэй	61	Налайх	10		Хан-Уул	55	Багануур	16
			Сүхбаатар	59	Багахангай	7		Сүхбаатар	54	Багахангай	10
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	137	Сүхбаатар	206	Сонгинохайрхан	96	132	Сүхбаатар	191	Сонгинохайрхан	88
			Чингэлтэй	155	Багахангай	83		Чингэлтэй	141	Налайх	67
			Баянзүрх	151	Багануур	64		Баянгол	136	Багахангай	60

Тайлбар: * промилль ** продицимил

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).


II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл
- ** дахин

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

мянга	=1000
сая	=10 ⁶
тэрбум	=10 ⁹
их наяд	=10 ¹²
мян	мянга
%	хувь
мм	миллиметр
см	сантиметр
дм	дециметр
м	метр
км	километр
м ²	метр квадрат
дм ²	дециметр квадрат
км ²	километр квадрат
м ³	метр куб
га	гектар
мл	миллилитр
л	литр
г	грамм
кг	килограмм
цн	центнер
т	тонн
Вт	ватт
кВт.ц	киловатт цаг
кал	калори
ккал	килокалори
Гкал	гигакалори(=10 ⁹ калори)
с	секунд
мин	минут
мкг/м ³	микрограмм метр куб
м/с	метр секунд
ш	ширхэг
х.д.х	хэвлэлийн даралтат хуудас



МЭДЭЭЛЭЛ



МЭДЭЭЛЭЛ, ОЙ САНАМЖ



ЭРҮҮЛ МЭНД (2021 оны эхний 10 сард)

ЭРҮҮЛ МЭНД

Амаржсан эх



2020 X 32 978

2021 X 30 623

7.1%



Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид



2020 X 14 173

2021 X 227 706

15.1 дахин



Нялхсын эндэгдлийн түвшин
(1000 амьд төрөлтөд ногдох)

2020 X

11.7

2021 X

11.3

5 хүртэлх насны хүүхдийн
эндэгдлийн түвшин
(1000 амьд төрөлтөд ногдох)

2020 X

13.2

2021 X

13.1

ЭРҮҮЛ МЭНД


Нийслэлийн хэмжээнд 2021 оны эхний 10 сард 30623 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 2355 (7.1%) төрөлтөөр буурсан байна. Нийт төрөлтийн 19062 (62.2%) нь НЭМГ-ын харьяа эмнэлэгт, 11561 (37.8%) нь нийслэлд үйл ажиллагаа явуулж буй ЭМЯ-ны харьяа улс болон хувийн хэвшлийн эмнэлэгт амаржсан байна. Нийт амаржсан эхчүүдийн 0.3 хувийг гэрийн төрөлт эзэлж байна.

Хүснэгт 3. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл, жил бүрийн эхний 10 сард

Үзүүлэлт	2019 I-X	2020 I-X	2021 I-X	$\frac{2021}{2020}$ %
Амаржсан эхийн тоо	33 946	32 978	30 623	-7.1
Гэрийн төрөлт	110	106	86	-18.9
Хяналтгүй төрөлт	203	167	83	-50.3
Амьд төрсөн хүүхэд	34 260	33 327	30 885	-7.3
Эхийн эндэгдэл	8	10	35	2.5**
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	441	389	348	-10.5
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	12.9	11.7	11.3	-

2021 оны эхний 10 сард 30885 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 2442 (7.3%) хүүхдээр цөөн байна. Төрсөн нийт хүүхдийн 4071 (13.2%) нь бусад аймгийн харьяат эхчүүдээс мэндэлжээ.


Зураг 1. Амьд төрсөн хүүхэд, дүүргээр



Төрсөн нийт хүүхдийн 15833 (51.3%) нь эрэгтэй, 15052 (48.7%) нь эмэгтэй хүүхэд байна. Амьд төрсөн нийт хүүхдээс 2 ихэр 436, 3 ихэр 6 байна. Мөн 3.5 хувь нь 2500 граммаас бага жинтэй, 0.5 хувь нь төрөлхийн гажигтай төржээ.

Амьгүй төрөлтийн 184 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор байна. Амьгүй төрөлт Баянгол, Сүхбаатар, Багахангай, Багануур дүүрэгт хотын дунджаас өндөр байна.


Зураг 2. Хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох), дүүргээр, эхний 10 сард



2021 оны эхний 10 сард бүртгэгдсэн нялхсын эндэгдлээс Сонгинохайрхан дүүрэгт 69 (19.8%) нь, Баянзүрх дүүрэгт 51 (14.7%) нь, Баянгол дүүрэгт 46 (13.2%) нь, Хан-Уул дүүрэгт 30 (8.6%) нь, Чингэлтэй дүүрэгт 26 (7.5%) нь, Сүхбаатар дүүрэгт 18 (5.2%) нь, Налайх дүүрэгт 14 (4.0%) нь, Багануур дүүрэгт 5 (1.4%) нь, бусад аймгийн харьяат 89 (25.6%), Багахангай дүүрэгт бүртгэгдээгүй байна.

Нийслэлд 2021 оны эхний 10 сард 227706 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 213533 (16.1 дахин их) хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 1437 продицимилээр тус тус өссөн байна.

Зураг 3. Халдварт өвчнөөр өвчлөгчид, сараар



Халдварт өвчнөөр өвчлөгчдийг халдварт өвчний төрлөөр нь авч үзвэл амьсгалын замын цочмог халдварт өвчин 223193 (98.0%), бэлгийн замаар дамжих халдварт өвчин 3341 (1.5%), гэдэсний халдварт өвчин 410 (0.2%), зоонозын халдварт өвчин 13 (0.01%), бусад халдварт өвчин 747 (0.3%) байна.

2021 оны эхний 10 сард **Коронавируст халдвар (COVID-19)**-ын 221887 тохиолдол бүртгэгдэж, нийт халдварт өвчний 97.4 хувийг эзэлж байна.

Хүснэгт 4. Нийслэлд гарсан халдварт өвчин, жил бүрийн эхний 10 сард

Төрөл	Хэмжих нэгж	2019 I-X	2020 I-X	2021 I-X	Өсөлт, бууралт 2021/2020	
					тоо/пункт	хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн, бүгд	бодит тоо 10000 хүнд	20 172 141.0	14 173 97.3	227 706 1 534.3	213 533 1 437	15.1**
Үүнээс:						
Вируст гепатит	бодит тоо 10000 хүнд	196 1.4	161 1.1	56 0.38	-105 -0.7	-65.2
Цусан суулга	бодит тоо 10000 хүнд	4 183 29.2	1 919 13.2	371 2.5	-1 548 -10.7	-80.7
Салхин цэцэг	бодит тоо 10000 хүнд	5 196 36.3	1 363 9.4	68 0.46	-1 295 -8.9	-95.0
Гахай хавдар	бодит тоо 10000 хүнд	38 0.3	39 0.3	1 0.0	-38 -0.3	-97.4
Сальмонеллөз	бодит тоо 10000 хүнд	245 1.7	158 1.1	14 0.1	-144 -1.0	-91.1
Улаан эсэргэнэ	бодит тоо 10000 хүнд	654 4.6	161 1.1	11 0.1	-150 -1.0	-93.2
Хоолны хордлого	бодит тоо 10000 хүнд	664 4.6	116 0.8	11 0.1	-105 -0.7	-90.5
Ёлом	бодит тоо 10000 хүнд	119 0.8	82 0.6	8 0.1	-74 -0.5	-90.2
Бруцеллөз	бодит тоо 10000 хүнд	16 0.1	9 0.1	5 0.0	-4 -0.1	-44.4
Гар хөл амны өвчин	бодит тоо 10000 хүнд	1 109 7.7	722 5	14 0.09	-708 -4.9	-98.1
Тэмбүү	бодит тоо 10000 хүнд	2 899 20.3	3 314 22.7	1 793 12.1	-1 521 -10.6	-45.9
Гонококкт халдвар	бодит тоо 10000 хүнд	1 484 10.4	1 966 13.5	809 5.5	-1 157 -8.0	-58.9
Трихомониаз	бодит тоо 10000 хүнд	1 311 9.2	1 639 11.2	728 4.9	-911 -6.3	-55.6
Сүрьеэ	бодит тоо 10000 хүнд	1 826 12.8	1 822 12.5	1 217 8.2	-605 -4.3	-33.2
ДОХ	бодит тоо 10000 хүнд	13 0.1	18 0.1	11 0.1	-7.0 -0.0	-38.9
Өөр бүлэгт ангилсан өвчний шалтгаан болох коронавирус – (Covid 19)	бодит тоо 10000 хүнд	- -	346 2.4	221 887 1 495	221 541 1 492.6	641.3**

Ойлголт, тодорхойлолт:

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.



ЦАГ УУР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ (2021 оны 10 дугаар сард)



Агаарын температур °C (Үнэмлэхүй их/бага)



14.5°C

Хамгийн дулаан хэм



-12.8°C

Хамгийн хүйтэн хэм

Гал түймрийн тоо



2021 X

1 239

23.1%↓

2020 X

1 611

Хүний үйл ажиллагаатай холбоотой осол



1

Үйлдвэрийн осол



171

Бусад

Байгаль орчны зөрчил



216

ЦАГ УУР, АГААРЫН ЧАНАР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ

Нийслэлийн агаарын дундаж хэм 2021 оны 10 дугаар сард дунджаар 1.6°C байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс 2.2°C-аар, олон жилийн дундажтай харьцуулбал 0.7°C-аар дулаан байв. Энэ сарын хамгийн дулаан хэм 14.5°C, хамгийн хүйтэн хэм -12.8°C, хур тунадасны нийлбэр 2.9 миллиметр, салхины үнэмлэхүй их хурд 16 метр секунд хүрсэн байна.

Хүснэгт 5. Агаарын бохирдолт, мг/м³, X сард¹

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хэмжилтийн тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO ₂	0.050	343	0.211	92	0.041
Азотын давхар исэл	NO ₂	0.050	226	0.082	62	0.040
Тоосжилт	PM ₁₀	0.100	333	0.446	139	0.104
	PM _{2.5}	0.050	227	0.121	51	0.035
Нүүрстөрөгчийн дутуу исэл²	CO	10.000	1 087	8.631	-	1.454
Озон	O ₃	0.100	416	0.078	-	0.023

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2021 оны 10 дугаар сард Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн дундаж агууламж 0.010 мг/м³ (32.0%)-ээр их байсан бол азотын давхар ислийн дундаж агууламж 0.001 мг/м³ (3.0%)-ээр, PM 2.5 тоосонцорын дундаж агууламж 0.010 мг/м³ (21.1%)-ээр, PM 10 тоосонцрын дундаж агууламж 0.014 мг/м³ (11.6%)-ээр тус тус бага байна.


Хүснэгт 6. Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисын агууламж агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас давсан тохиолдлын тоо, станц, 2021 оны X сард

Станцын байршил	Хүхэрлэг хий (SO ₂)	Азотын давхар исэл (NO ₂)	Нүүрс төрөгчийн дутуу исэл (CO)	Тоос (PM ₁₀)	Тоос (PM _{2.5})	Озон (O ₃)
Мишээл экспо	-	-	-	-	-	-
Баруун 4 зам	-	29	-	12	1	-
1-р хороолол	22	-	-	17	10	-
13-р хороолол	5	17	-	16	1	-
32-ын тойрог	-	-	-	20	-	-
Хархорин	-	13	-	18	-	-
Ургах наран хороолол	-	-	-	11	-	-
Хайлааст	13	-	-	18	16	-
248-р цэцэрлэг	6	-	-	1	13	-
Богд хааны ордон музей	-	-	-	-	-	-
Нисэх	-	-	-	-	-	-
Толгойт	-	-	-	-	-	-
Зурагт	23	-	-	4	10	-
Амгалан	23	3	-	-	-	-
Баянхошуу	-	-	-	22	-	-


¹ Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар

² 8 цагийн дундаж


Зураг 4. Улаанбаатар³ хотын агаар дахь хүхэрлэг хийн агууламж, 13 станцын дундаж, мг/м³



Зураг 5. Улаанбаатар³ хотын агаар дахь азотын давхар ислийн агууламж, 11 станцын дундаж, мг/м³



Зураг 6. Улаанбаатар³ хотын агаар дахь 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж, 12 станцын дундаж, мг/м³



Туул голын усны бохирдол:

Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн 2021 оны 10 дугаар сарын 06, 07-ны өдөр хийсэн хэмжилтээр Туул голын усны найрлага Туул-Налайх харуул цэгийн орчимд хэвийн, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 4.3 дахин, амоны азот 4 дахин, эрдэс фосфор 1.3 дахин хүлцэх хэмжээнээс давж Туул голын ус бохирдолтой хэвээр байна.

Хүснэгт 7. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м³, X сард⁴

Үзүүлэлт		Стандарт хэмжээ	“Туул-Налайх” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
			Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч	O ₂	≥6	10.10	Хэвийн	4.47	хэвийн
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч	BXX ₅	≤3	1.8	Хэвийн	13.1	4.3 дахин
Нитритийн нэгдэл	NO ₂	≤0.02	0.001	Хэвийн	0.024	хэвийн
Амоны азот	NH ₄	≤0.5	0.16	Хэвийн	2.0	4 дахин
Эрдэс фосфор	P	≤0.1	0.004	Хэвийн	0.127	1.3 дахин

³ Багануур, Багахангай, Налайх дүүрэгт агаарын бохирдол хэмжих харуул цэг байхгүй.

⁴ Эх үүсвэр: Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори

Хүснэгт 8. Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м³, X сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл- Экспо төв	Баруун дөрвөн зам	I хороолол	XIII хороолол	32-ын тойрог	Хархорин зах	Ургах наран хороолол	Хайлааст	248-р цэцэрлэг	Богд хааны ордон музей	Нисэх	Толгойт	Зурагт	Амгалан	Баян- хошуу
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж	0.014	0.021	0.076	0.029	0.017	0.016	0.008	0.049	0.040	0.014	-	-	0.125	0.082	-
	Хамгийн их XXX*-с давсан хувь	0.029	0.044	0.144	0.060	0.037	0.029	0.033	0.090	0.110	0.026	-	-	0.211	0.162	-
		-	-	71.0	16.0	-	-	-	50.0	19.0	-	-	-	88.0	74.0	-
	Хэмжилтийн тоо	26	26	31	31	31	28	25	26	31	31	-	-	26	31	-
Азотын давхар исэл NO ₂	Дундаж	-	0.067	-	0.048	-	0.050	0.027	0.029	0.031	0.033	-	-	-	0.034	-
	Хамгийн их XXX*-с давсан хувь	-	0.082	-	0.064	-	0.069	0.045	0.037	0.042	0.046	-	-	-	0.058	-
		-	93.0	-	55.0	-	62.0	-	-	-	-	-	-	-	10.0	-
	Хэмжилтийн тоо	-	31	-	31	-	21	25	26	30	31	-	-	-	31	-
Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	0.546	1.581	2.16	1.293	1.217	0.963	0.198	2.621	-	0.714	2.291	2.571	1.920	0.825	-
	Хамгийн их XXX*-с давсан хувь	1.347	4.978	7.017	5.688	3.264	3.677	2.010	6.203	-	4.353	6.299	8.631	8.551	5.664	-
		-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	85	93	93	93	93	86	79	79	-	92	57	93	93	51	-
Тоос PM ₁₀	Дундаж	0.036	0.090	0.117	0.103	0.112	0.117	0.101	0.121	0.065	0.048	-	-	0.070	-	0.267
	Хамгийн их XXX*-с давсан хувь	0.051	0.156	0.199	0.200	0.164	0.242	0.177	0.215	0.147	0.089	-	-	0.108	-	0.446
		-	39.0	63.0	52.0	65.0	64.0	44.0	69.0	3.0	-	-	-	15.0	-	92.0
	Хэмжилтийн тоо	28	31	27	31	31	28	25	26	29	27	-	-	26	-	24
Тоос PM _{2.5}	Дундаж	-	0.030	0.039	0.030	-	-	-	0.058	0.051	0.004	-	0.025	0.041	-	-
	Хамгийн их XXX*-с давсан хувь	-	0.052	0.066	0.051	-	-	-	0.089	0.121	0.013	-	0.040	0.069	-	-
		-	3.0	32.0	3.0	-	-	-	62.0	54.0	-	-	-	38.0	-	-
	Хэмжилтийн тоо	-	31	31	29	-	-	-	26	24	31	-	29	26	-	-
Озон O ₃ **	Дундаж	-	-	-	0.015	0.016	-	0.026	-	-	-	-	0.023	0.022	0.034	-
	Хамгийн их XXX*-с давсан хувь	-	-	-	0.049	0.043	-	0.078	-	-	-	-	0.052	0.067	0.069	-
		-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	-	-	93	72	-	79	-	-	-	-	44	35	93	-

* Хүлцэх хэм хэмжээ,

**CO, O₃-ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон

Байгаль орчны зөрчил:

Нийслэлийн хэмжээнд 2021 оны эхний 10 сард байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 216 зөрчлийг илрүүлжээ. Илрүүлсэн нийт зөрчлийн 16.7 хувийг ан амьтны зөрчил, 41.7 хувийг газрын зөрчил, 17.6 хувийг геодези зураг зүй, кадастрын зөрчил, 10.6 хувийг газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхайн зөрчил, 2.8 хувийг усны зөрчил, 3.2 хувийг агаар, химийн хорт бодисын зөрчил, 4.2 хувийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний зөрчил, 1.8 хувийг ойн зөрчил, 1.4 хувийг бусад зөрчил тус тус эзэлж байна. Илрүүлсэн нийт зөрчилд 382.1 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Хүснэгт 9. Байгаль орчны зөрчил, төрлөөр, 2021 оны эхний 10 сард⁵

Илрүүлсэн зөрчил, төрлөөр	2020 I-X			2021 I-X		
	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль (сая төгрөг)	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль (сая төгрөг)
Бүгд	310	310	296.8	216	216	382.1
Ой	1	1	0.3	4	4	1.2
Ан, амьтан	9	9	15.8	36	36	45.9
Газрын	123	123	143.5	90	90	170.0
Ус	3	3	4.5	6	6	89.9
Ургамал, хөрсний бохирдол	-	-	-	-	-	-
Агаар, химийн хорт бодис	7	7	14.1	7	7	18.3
Газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхай	39	39	48.2	23	23	28.9
Геодези зураг зүй, кадастр	77	77	14.0	38	38	12.9
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	30	30	38.5	9	9	13.9
Бусад	21	21	17.9	3	3	1.1

АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ

Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2021 оны эхний 10 сард 175 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7.9 хувиар буурсан байна. Нийт гамшигт хүчтэй салхи шуурга 2, аадар бороо, үер 1, бог малын мялзан өвчин 1, хүний үйл ажиллагаатай холбоотой 171 осол бүртгэгдсэн. Хүний үйл ажиллагаатай холбоотой осолд үйлдвэрийн 1 осол, сум галт хэрэгслийн 1 осол, усны 39 осол, тэсрэх дэлбэрэх бодисын 2 осол, бусад төрлийн 128 осол бүртгэгдсэн. Гамшгийн улмаас 53 хүн амь насаа алдаж, 176 хүнийг аварч, гамшгийн уршгийг арилгах ажилд нийт 5.1 сая төгрөг зарцуулжээ.

Хүснэгт 10. Гал түймрийн тоо, дүүргээр, оны эхний 10 сард


Дүүрэг	2016	2017	2018	2019	2020	2021	$\frac{2021}{2020}$ %
Нийслэлийн дүн	2 103	2 087	2 108	2 457	1 611	1 239	76.9
Багануур	39	28	24	37	26	21	80.8
Багахангай	7	3	5	5	4	8	200.0
Баянгол	354	306	347	322	204	165	80.9
Баянзүрх	516	481	485	587	368	294	79.9
Налайх	81	71	71	46	48	33	68.7
Сонгинохайрхан	453	465	447	623	403	292	72.4
Сүхбаатар	239	282	235	323	206	172	83.5
Хан-Уул	186	215	301	241	172	128	74.4
Чингэлтэй	228	236	193	273	180	126	70.0

Нийслэл хотод 2021 оны эхний 10 сард ахуйн 1239 гал түймэр гарч өмнөх оны мөн үеэс 23.1 хувиар бууржээ. Гал түймрийн улмаас 30 хүн (үүнээс, хүүхэд 7) амь насаа алдаж, 30 хүн түлэгдэж гэмтсэн байна. Худал дуудлагын тоо 15 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3 (16.6%)-аар буурав.


⁵ Эх үүсвэр: НМХГ-ын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын хэлтэс

Гал түймрийн аюулаас 881 хүн, 404 байшин барилга, 63.1 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг аварсан байна. Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилбал цахилгаанаас 341, санамсаргүй байдлаас 800, санаатай үйлдлээр 2, шалтгаан тогтоогдоогүй 6, бусад шалтгаанаар 90 гал түймэр гарчээ.

Зураг 7. Гал түймэр, байршлаар



Зураг 8. Гал түймэр, шалтгаанаар



Гал түймэрт 724 гэр, орон сууц, 53 барилга байгууламж, тоног төхөөрөмж, 100 машин техник, малын 9 хашаа, саравч, бусад төрлийн 353 объект өртжээ. Гал түймэрт иргэний хувийн өмчийн 881, төрийн өмчийн 299, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 59 объект өртөж, нийт 2589.5 сая төгрөгийн хохирол учирсан байна.

Нийслэлийн Онцгой байдлын газраас 2021 оны эхний 10 сард 115 барилгын зураг төсөл, мөн ашиглалтад хүлээн авч буй 415 барилгад хяналт тавьж ажиллажээ. Түүнчлэн 14345 айл өрх, 7539 объектод үзлэг шалгалт хийж, 20003 галын зөрчил илрүүлж, 1 байгууллагын үйл ажиллагааг нь зогсоож, байгууллага, албан тушаалтан, иргэнд 1543 заавал биелүүлэх албан шаардлага, 1900 мэдэгдэл хүргүүлж, 71.0 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Ойлголт, тодорхойлолт

Агаарын бохирдол: Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.



ГЭМТ ХЭРЭГ (2021 оны эхний 10 сард)

ᠭᠡᠮᠡᠲᠡ ᠬᠡᠷᠡᠭ



Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (дүүргээр)

2020 X

13 399

2021 X

12 926

3.5%↓



↓↑ Өмнөх оны мөн үетэй харьцуулахад, хувиар

Гэмт хэргийн улмаас



Хохирсон хүн

12 628



Гэмтсэн хүн

3 656



Нас барсан хүн


247

ГЭМТ ХЭРЭГ

2021 оны эхний 10 сард 12926 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 473 (3.5%) хэргээр буурч, гэмт хэргийн илрүүлэлт 48.2 хувьтай байгаа нь 3.0 пунктээр өссөн байна.

Гэмт хэргийн улмаас 3656 хүн гэмтэж осолдон, 247 хүн нас барж, төр ард иргэдэд 116.8 тэрбум төгрөгийн хохирол учруулснаас 51.7 тэрбум (44.3%) төгрөгийг нөхөн төлүүлжээ.

Зураг 9. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 32.3 хувийг залилан, 27.8 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 19.6 хувийг хулгайн, 2.7 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг, 1.9 хувийг дээрмийн, 1.4 хувийг бусдын хөрөнгө ашиглах, 1.4 хувийг хүчин, 0.7 хувийг хүн амь, 1.2 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 0.1 хувийг танхай, 10.9 хувийг бусад гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Хүснэгт 11. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, төрлөөр, жил бүрийн эхний 10 сард

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өсөлт, бууралт, 2021/2020	
	2019 I-X	2020 I-X	2021 I-X	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	18 716	13 399	12 926	-473	-3.5
Хүний амь	100	90	95	5	5.6
Хүчин	216	179	183	4	2.2
Дээрэм	671	325	251	-74	-22.8
Хулгай	6 091	3 495	2 531	-964	-27.6
Залилан	3 738	3 210	4 167	957	29.8
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	4 478	3 912	3 591	-321	-8.2
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	526	361	351	-10	-2.8
Бусдыг амиа хорлоход хүргэх	253	134	158	24	17.9
Ашиглах	312	219	180	-39	-17.8
Танхайрах	16	9	6	-3	-33.3
Бусад	2 315	1 465	1 413	-52	-3.5

2021 оны эхний 10 сард 43090 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 18222 (29.79%) хүнээр буурсан байна.

Хүснэгт 12. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, дүүргээр, жил бүрийн эхний 10 сард


Дүүрэг	Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг			Өсөлт, бууралт 2021/2020	
	2019 I-X	2020 I-X	2021 I-X	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	18 716	13 399	12 926	-473	-3.5
Багануур	165	124	134	10	8.1
Багахангай	14	23	18	-5	-21.7
Баянгол	2 901	2 109	2 073	-36	-1.7
Баянзүрх	4 956	3 647	3 264	-383	-10.5
Налайх	288	308	224	-84	-27.3
Сонгинохайрхан	3 255	2 098	2 367	269	12.8
Сүхбаатар	2 966	2 049	1 862	-187	-9.1
Хан-Уул	1 839	1 460	1 556	96	6.6
Чингэлтэй	2 332	1 581	1 428	-153	-9.7

2021 оны эхний 10 сард бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 11 560 (89.4%) нь хөнгөн хэрэг, 1 366 (10.6%) нь хүнд хэрэг байна.⁶

Хүснэгт 13. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо, дүүргээр, 2021 оны эхний 10 сард

Дүүрэг	Хэрэг бүртгэлтийн Хэргийн тоо	Үүнээс:	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
		Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэрэг	
Нийслэлийн дүн	10 267	4 949	48.2
Багануур	88	41	46.6
Багахангай	4	3	75.0
Баянгол	1 639	905	55.2
Баянзүрх	2 608	1 205	46.2
Налайх	109	62	56.9
Сонгинохайрхан	2 051	979	47.7
Сүхбаатар	1 180	469	39.7
Хан-Уул	1 390	672	44.6
Чингэлтэй	1 198	613	51.2

Зураг 10. Гэмт хэргийн илрүүлэлт, 2021 оны эхний 10 сард



⁶ Монгол Улсын Эрүүгийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж 2 ангилдаг болсон.

“Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2021 оны X сарын танилцуулга

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 2021 оны эхний 10 сард 8310 болж, өмнөх оны мөн үеэс 253 (3.1%) хүнээр өссөн байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 1917 (23.1%) нь согтуугаар, 1044 (12.6%) нь гэмт хэргийг бүлэглэн үйлджээ. Сэжигтэн, яллагдагчийн 443 (5.3%) нь хүүхэд, 1790 (21.5%) нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 14. Бүртгэгдсэн хулгайн гэмт хэрэг, дүүргээр, жил бүрийн эхний 10 сард

Дүүрэг	Хулгайн гэмт хэргийн тоо, бүгд			Үүнээс:		
				Хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо		
	2019 I-X	2020 I-X	2021 I-X	2019 I-X	2020 I-X	2021 I-X
Нийслэлийн дүн	6 091	3 495	2 531	5 443	3 156	2 187
Багануур	37	21	14	30	19	13
Багахангай	2	6	4	2	5	3
Баянгол	851	367	408	716	288	315
Баянзүрх	1 701	964	603	1 510	836	509
Налайх	80	65	20	78	58	19
Сонгинохайрхан	1 201	701	547	1 123	669	507
Сүхбаатар	930	549	354	848	508	304
Хан-Уул	516	405	355	441	381	326
Чингэлтэй	773	417	226	695	392	191

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000- аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.


Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.




ТӨСӨВ (2021 оны эхний 10 сард)


Авчир



Төсвийн орлого, зарлагын бүтэц



■ Татварын орлого
■ Татварын бус орлого



■ Урсгал зардал
■ Хөрөнгийн зардал

НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВ


Нийслэлийн төсвийн нийт орлого 2021 оны эхний 10 сард 921.7 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 19.2 (2.0%) тэрбум төгрөгөөр дутуу бүрджээ. Төсвийн нийт орлогын 830.6 (90.1%) тэрбум төгрөгийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 91.1 (9.9%) тэрбум төгрөгийг татварын бус орлого тус тус эзэлж байна.

2021 оны эхний 10 сард нийслэлийн татварын орлого 830.6 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 34.9 (4.0%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн хэдий ч татварын бус орлого 91.0 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 15.7 (20.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Орлогын албан татвар төлөвлөснөөс 15.9 (2.6%) тэрбум төгрөгөөр, хөрөнгийн албан татвар 12.9 (13.8%) тэрбум төгрөгөөр, бусад татвар, төлбөр, хураамж 6.0 (4.0%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан.

Татварын бус орлого төлөвлөснөөс 15.7 (20.8%) тэрбум төгрөгөөр өсөхөд торгуулийн орлого голлон нөлөөлсөн байна.

Зураг 11. Нийслэлийн төсвийн орлого, сая төгрөг



Хүснэгт 15. Нийслэлийн төсвийн орлого, дүүргээр, сая төгрөг оны эхний 10 сард

Дүүрэг	Төсвийн орлого			Үүнээс:					
				Татварын орлого			Татварын бус орлого		
	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь
Нийслэлийн дүн	940 970.2	921 721.5	98.0	865 575.0	830 642.6	96.0	75 395.2	91 078.9	120.8
Багануур	1 935.8	2 657.4	137.3	1 408.5	1 842.2	130.8	527.3	815.2	154.6
Багахангай	353.6	490.8	138.8	120.8	104.6	86.5	232.8	386.2	165.9
Баянгол	28 616.2	31 016.2	108.4	26 056.9	28 604.4	109.8	2 559.3	2 411.8	94.2
Баянзүрх	39 726.0	49 083.1	123.6	38 303.1	47 117.4	123.0	1 422.9	1 965.7	138.2
Налайх	2 083.8	3 186.5	152.9	1 600.3	2 437.6	152.3	483.5	748.9	154.9
Сонгинохайрхан	17 633.0	20 925.2	118.7	16 804.4	20 116.2	119.7	828.6	809.0	97.6
Сүхбаатар	64 879.9	63 350.9	97.6	63 263.6	61 564.3	97.3	1 616.3	1 786.6	110.5
Хан-Уул	65 728.3	52 266.6	79.5	63 244.5	50 017.1	79.1	2 483.8	2 249.5	90.6
Чингэлтэй	59 771.5	81 103.6	135.7	58 166.8	79 808.8	137.2	1 604.7	1 294.8	80.7
Хотын шууд	660 242.1	617 641.2	93.5	596 606.1	539 030.0	90.3	63 636.0	78 611.2	123.5

Хүснэгт 16. Нийслэлийн төсвийн орлого, сая төгрөг оны эхний 10 сард


Үзүүлэлт	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
Нийт орлого	940 970.2	921 721.5	98.0
1. Татварын орлого	865 575.0	830 642.6	96.0
Орлогын албан татвар	619 594.4	603 611.3	97.4
Хувь хүний орлогын албан татвар	647 594.4	621 301.1	95.9
Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын	465 300.0	421 604.8	90.6
Үйл ажиллагааны орлогын	32 869.4	30 671.2	93.3
Хөрөнгийн орлого	82 462.7	88 810.1	107.7
Хөрөнгө борлуулсны орлогын	13 012.8	42 285.1	3.2**
Шууд бус орлого	53 949.5	37 929.9	70.3
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-28 000.0	-17 689.8	63.2
Хөрөнгийн албан татвар	93 690.9	80 786.6	86.2
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	61 150.0	49 649.5	81.2
Бууны албан татвар	346.5	264.9	76.4
Малд ногдуулах албан татвар	44.4	17.6	39.7
Авто тээврийн ба өөрөө явагч хэрэгслийн	32 150.0	30 854.6	96.0
Бусад татвар, төлбөр, хураамж	152 289.7	146 244.7	96.0
Бусад нийтлэг төлбөр, хураамж	54 860.4	73 477.8	133.9
Газрын төлбөр	87 451.7	65 990.4	75.5
Байгалийн нөөц ашигласны төлбөр	3 582.6	2 319.9	64.8
Бусад татвар	6 395.0	4 456.6	69.7
2. Татварын бус орлого	75 395.2	91 078.9	120.8
Нийтлэг татварын бус орлого	75 395.2	90 892.8	120.5
Хувьцаа ногдол ашиг, Хүүгийн орлого	235.1	125.7	53.5
Төсөвт байгууллагын өөрийн орлого	11 810.8	6 290.5	53.3
Торгуулийн орлого	43 820.4	62 018.9	141.5
Түрээсийн орлого	1 684.0	1 652.4	98.1
Бусад орлого	17 844.9	20 805.3	116.6
Өмч хувьчлал	-	186.1	-

2021 оны эхний 10 сард нийслэлийн төсвөөс нийслэл, дүүргийн байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 959.4 (60.0%) тэрбум төгрөгийг санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл нийслэл, дүүргийн байгууллагууд батлагдсан төсвийнхөө 639.5 (40.0%) тэрбум төгрөгийг зарцуулаагүй байна.


Хүснэгт 17. Нийслэлийн төсвийн зарлага, сая төгрөг, оны эхний 10 сард

Дүүрэг	Зарлага			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийслэлийн дүн	1 599 028.1	959 436.1	639 592.0	60.0
Багануур	20 573.6	16 745.1	3 828.5	81.4
Багахангай	5 734.2	5 183.4	550.8	90.4
Баянгол	87 978.4	77 195.1	10 783.3	87.7
Баянзүрх	132 737.3	114 081.1	18 656.2	85.9
Налайх	20 870.5	18 951.5	1 919.0	90.8
Сонгинохайрхан	111 878.0	98 442.6	13 435.4	88.0
Сүхбаатар	142 192.2	118 036.4	24 155.8	83.0
Хан-Уул	127 055.6	94 906.6	32 149.0	74.7
Чингэлтэй	102 884.5	84 627.2	18 257.3	82.3
Хотын шууд	847 123.8	331 267.1	515 856.7	39.1

Зураг 12. Нийслэлийн төсвийн зарлага, сая төгрөг



Зураг 13. Нийслэлийн төсвийн орлого, зарлага, сая төгрөг



Ойлголт, тодорхойлолт:

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн орлого: Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (2021 оны 10 дугаар сард)

ХҮҮННИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БҮС ҮНДАА

Ерөнхий индекс

9.3

Хүнсний бараа, согтууруулах бүс ундаа

18.5

Тээвэр

17.0

Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ

14.3

Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ

7.6

Бусад бараа, үйлчилгээ

6.7

Боловсролын үйлчилгээ

6.7

Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис

5.0

Гэр ахуйн тавилга, бараа

2.9

Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ

2.7

Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ

1.6

Хувцас, бөс бараа, гутал

0.8

-2.6

Орон сууц, үс, цахилгаан, хийн болон бусад түлш


-18 -12 -9 -6 -3 0 3 6 9 12 18

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 9.3 хувиар өслөө.

2021 оны 10 дугаар сарын хэрэглээний үнийн индекс 2020 оны эцэстэй харьцуулахад 10.4 хувиар өсч, харин өмнөх сартай харьцуулахад тогтвортой байна.

Зураг 14. Хэрэглээний үнийн индекс



Хэрэглээний үнийн индекс 2021 онд өмнөх оны эцэстэй харьцуулахад 10.4 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 15.6 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис бүлгийн үнэ 4.7 хувь, хувцас, бөс бараа, гутал бүлгийн үнэ 0.5 хувиар, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ 15.0 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 2.5 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ бүлгийн үнэ 6.7 хувь, тээвэр бүлгийн үнэ 17.0 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ бүлгийн үнэ 2.7 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 1.5 хувь, боловсролын үйлчилгээ бүлгийн үнэ 6.7 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн үнэ 14.3 хувь, бусад бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 6.2 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 18. Хэрэглээний үнийн индекс, барааны бүлгээр


Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	<u>2020-X</u> 2019-X	<u>2021-X</u> 2020-X	<u>2021-X</u> 2020-XII	<u>2021-X</u> 2021-IX
Ерөнхий индекс	102.6	109.3	110.4	100.0
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	102.9	118.5	115.6	103.0
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	105.4	105.0	104.7	100.9
Хувцас, бөс бараа, гутал	104.9	100.8	100.5	101.2
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	103.8	97.4	115.0	89.9
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	103.0	102.9	102.5	100.5
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	102.9	107.6	106.7	100.1
Тээвэр	96.9	117.0	117.0	100.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.1	102.7	102.7	100.6
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	100.8	101.6	101.5	100.1
Боловсролын үйлчилгээ	100.6	106.7	106.7	101.1
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	105.8	114.3	114.3	100.0
Бусад бараа, үйлчилгээ	106.5	106.7	106.2	100.2

2021 оны 10 дугаар сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 344 нэрийн бараа, үйлчилгээний 35.2 хувийнх нь үнэ өсөж, 2.3 хувийнх нь үнэ буурч, 62.5 хувийн бараа үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад тогтвортой байв.


Хүснэгт 19. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн сарын индекс, /**зэрэг, сөрөг**/

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	3.0	Энэ бүлгийн үнийн өсөлтөд сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ 6.8 хувиар, хүнсний ногооны үнэ 13.0 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлөв.
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	0.9	Энэ бүлгийн үнийн өсөлтөд шар айргийн үнэ 0.8 хувиар, тамхины үнэ 1.4 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлөв.
Хувцас, бөс бараа, гутал	1.2	Хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнийн өсөлтөд хөвөн, бөс барааны үнэ 2.3 хувиар, жижиг эдлэл, хэрэгслийн үнэ 1.8 хувиар, гутал засвар, түрээсийн үнэ 5.0 хувиар өссөн нь тус тус голлон нөлөөлөв.
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	10.1	Энэ бүлгийн үнийн бууралтад хатуу түлшний үнэ 24.1 хувиар буурсан нь шууд нөлөөлөв.
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	0.5	Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнийн өсөлтөд гэр ахуйн удаан эдэлгээт цахилгаан болон бусад барааны үнэ 2.4 хувиар, гэр ахуйн барааны үнэ 0.3 хувиар тус тус өссөн нь нөлөөлөв.
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	0.1	Энэ бүлгийн үнийн өсөлтөд эм, тарианы үнэ 0.2 хувиар өссөн нь шууд нөлөөлөв.
Тээвэр	0.2	Тээврийн бүлгийн үнийн өсөлтөд хувийн тээврийн хэрэгслийн шатах, тослох материалын үнэ 0.4 хувиар өссөн нь шууд нөлөөлжээ.
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	0.6	Энэ бүлгийн үнийн өсөлтөд телефон утас, факсын үйлчилгээний үнэ 0.6 хувиар өссөн нь шууд нөлөөлжээ.
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	0.1	Энэ бүлгийн үнийн өсөлтөд фото зураг, кино зургийн хэрэгсэл, дурангийн үнэ 4.2 хувиар өссөн нь нөлөөлжээ.
Боловсролын үйлчилгээ	1.1	Боловсролын үйлчилгээ бүлгийн үнийн өсөлтөд боловсрол олгох бусад үйлчилгээний үнэ 31.0 хувиар өссөн нь нөлөөлжээ.
Бусад бараа, үйлчилгээ	0.2	Энэ бүлгийн үнийн өсөлтөд гоо сайхны хэрэгцээнд зориулсан бусад эд зүйлсийн үнэ 0.3 хувиар өссөн нь нөлөөлжээ.


Зураг 15. Нэг ширхэг талхны дундаж үнэ, жил бүрийн X сард, төгрөг



Зураг 16. Нэг килограмм савласан гурилын дундаж үнэ, жил бүрийн X сард, төгрөг




Зураг 17. Нэг килограмм хүнсний ногооны дундаж үнэ, жил бүрийн X сард, төгрөг



Зураг 18. Нэг килограмм хүнсний ногооны дундаж үнэ, жил бүрийн X сард, төгрөг



Зураг 19. Нэг литр сүү, таргийн дундаж үнэ, жил бүрийн X сард, төгрөг




2021 оны 10 дугаар сард хүнсний зах, супермаркет, бөөний төвүүдэд жижиглэн худалдаалагдаж буй хонины ястай махны үнэ өмнөх сартай харьцуулахад 1.0 хувиар буурч, харин үхрийн ястай махны үнэ 0.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 20. Нэг килограмм махны жижиглэн худалдах дундаж үнэ, төгрөг


Үхрийн ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2016	6 165	6 875	7 105	8 170	8 495	7 930	6 950	6 865	6 120	5 235	5 495	5 580
2017	6 775	7 405	7 785	7 985	8 230	7 905	7 725	7 375	7 250	6 945	6 710	6 505
2018	6 615	7 110	7 740	8 365	8 465	8 735	9 085	8 225	7 780	7 845	8 005	8 305
2019	8 875	8 925	9 390	9 635	10 960	11 700	12 280	11 540	11 375	10 950	10 090	9 755
2020	10 535	11 415	11 665	11 735	11 940	12 640	12 760	11 760	11 235	10 855	11 075	11 210
2021	11 615	12 605	12 670	13 850	13 960	14 770	14 800	13 700	13 420	13 280		

Хонины ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2016	4 625	5 495	5 970	6 935	6 945	6 525	5 780	5 605	4 940	4 250	3 945	4 390
2017	5 650	6 030	6 675	7 080	7 235	6 700	6 575	6 395	6 210	5 760	5 380	5 140
2018	5 240	5 945	6 560	7 290	7 490	7 515	7 535	6 980	6 415	6 440	6 690	6 695
2019	7 170	7 340	7 945	8 710	9 820	10 430	10 045	9 700	9 640	9 095	7 710	7 635
2020	8 705	9 600	9 765	9 835	10 125	10 385	10 650	9 870	9 170	8 715	8 635	8 580
2021	9 040	10 460	10 705	12 320	12 390	12 695	12 440	11 380	10 975	11 005		

Зураг 20. Нэг кг хонины махны дундаж үнэ



Зураг 21. Нэг кг үхрийн махны дундаж үнэ



Зураг 22. Нэг литр шатахууны үнэ, өөрчлөлт орсон өдрөөр




Хүснэгт 21. Түлшний үнэ, төгрөг

Байршил	2019.X.30			2020.X.30			2021.X.27		
	Түлшний мод шуудай (6-7 кг)		Сайжруулсан түлш 25 кг	Түлшний мод шуудай (6-7 кг)		Сайжруулсан түлш 25 кг	Түлшний мод шуудай (6-7 кг)		Сайжруулсан түлш 25 кг
	Хар мод	Нарс мод		Хар мод	Нарс мод		Хар мод	Нарс мод	
Чингэлтэй	4 000	3 500	3 750	3 500	3 000	3 750	5 000	5 000	1 875
Сүхбаатар	4 000	3 500	3 750	3 500	3 000	3 750	5 000	4 500	1 875
Цайз зах	4 000	3 500	3 750	4 000	4 000	3 750	5 000	5 000	1 875
Хангай зах	3 500	3 500	3 800	3 000	2 500	3 750	4 000	3 500	1 875
Дундаж үнэ	3 875	3 500	3 763	3 500	3 125	3 750	4 750	4 500	1 875

Хүснэгт 22. Нэг литр шатахууны үнэ, төгрөг

ШТС	2020.X.28					2021.X.27				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	-	1 300	1 370	1 850	-	-	1 940	2 050	2 430	-
Петровис	2 000	1 400	1 450	2 090	-	2 550	2 000	2 050	2 690	-
Магнай трейд	2 000	-	1 420	2 090	-	2 550	-	2 050	2 690	-
Сод монгол	2 000	-	1 450	2 090	-	2 650	-	2 050	2 690	-
Шунхлай	2 000	-	1 420	2 090	-	2 550	-	2 050	2 590	-
Юнигаз	-	-	-	-	1 130	-	-	-	-	1 855
Дундаж үнэ	2 000	1 350	1 422	2 042	1 130	2 575	1 970	2 050	2 618	1 855

Зураг 23. Ам.долларын ханшийн сарын дундаж хөдөлгөөн, төгрөг⁷



⁷ Эх үүсвэр: Монголбанкны статистик мэдээлэл

“Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2021 оны X сарын танилцуулга

Хүснэгт 23. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2021 оны VIII, IX, X сарын өдрүүдээр

Д/д	Бүтээгдэхүүний нэр		хэмжих нэгж	2021 VIII.11	2021 VIII.18	2021 VIII.25	2021 IX.01	2021 IX.08	2021 IX.15	2021 IX.22	2021 IX.29	2021 X.06	2021 X.13	2021 X.20	2021 X.27	21.X.27 21.X.20
1	"Алтан тариа" гурил	Дээд	кг	1 584	1 584	1 584	1 584	1 584	1 584	1 584	1 584	1 584	1 584	1 584	1 584	100.0
		1-р зэрэг	кг	1 376	1 376	1 376	1 376	1 376	1 376	1 376	1 376	1 376	1 376	1 376	1 386	100.7
2	"Алтан тариа" савласан гурил	Дээдийн дээд	кг	2 236	2 236	2 236	2 236	2 236	2 236	2 236	2 236	2 236	2 236	2 236	2 236	100.0
		Дээд	кг	1 619	1 619	1 619	1 619	1 619	1 619	1 619	1 619	1 619	1 619	1 619	1 619	100.0
		1-р зэрэг	кг	1 414	1 414	1 414	1 414	1 414	1 414	1 414	1 414	1 414	1 414	1 414	1 424	100.7
		2-р зэрэг	кг	998	998	998	998	998	998	998	998	1 012	1 012	1 012	1 012	100.0
3	Сүү	Сүү ХК 1л	литр	2 841	2 841	2 841	2 841	3 033	3 041	3 067	3 067	3 083	3 083	3 083	3 083	100.0
		Сүү ХК 0.5л	литр	1 325	1 325	1 325	1 325	1 453	1 453	1 453	1 453	1 461	1 461	1 461	1 461	100.0
		Задгай	литр	1 649	1 649	1 649	1 649	1 649	1 649	1 844	1 844	1 844	1 949	1 949	1 949	100.0
4	Тараг, Цөцгийтэй		литр	2 740	2 740	2 740	2 740	2 964	3 007	3 016	3 016	3 041	3 041	3 041	3 041	100.0
5	Талх	Атар	ширхэг	1 280	1 280	1 280	1 280	1 484	1 500	1 500	1 500	1 500	1 500	1 500	1 500	100.0
		Зууван чех	ширхэг	1 699	1 699	1 699	1 699	1 777	1 817	1 817	1 817	1 874	1 874	1 874	1 901	101.4
		Хар талх	300 гр	1 224	1 224	1 224	1 224	1 307	1 332	1 332	1 332	1 332	1 332	1 332	1 332	100.0
6	Будаа	Цагаан	кг	3 671	3 671	3 724	3 724	3 754	3 754	3 754	3 754	3 754	3 754	3 754	3 899	103.9
		Шар	кг	2 470	2 470	2 523	2 523	2 523	2 523	2 523	2 523	2 523	2 523	2 523	2 523	100.0
7	Цөцгийн тос, "Сүү" ХК		200 гр	4 638	4 696	4 696	4 696	4 696	4 696	4 696	4 696	4 696	4 696	4 696	5 888	125.4
8	Ургамлын тос, "Янта"		1 литр	4 774	4 821	4 821	4 821	4 821	4 821	4 821	4 864	4 864	4 864	4 873	5 473	112.3
9	Ногоон цай, Сtimo		90 гр	1 566	1 566	1 566	1 566	1 566	1 566	1 566	1 566	1 566	1 610	1 610	1 902	118.1
10	Элсэн чихэр		кг	2 713	2 713	2 800	2 800	2 800	2 800	2 800	2 800	2 800	2 800	2 800	2 863	102.3
11	Хонины мах	Ястай	кг	11 598	11 162	11 152	11 145	11 090	10 906	10 865	10 865	10 834	11 226	10 996	10 974	99.8
		Цул	кг	11 569	11 244	11 207	11 144	11 244	10 767	10 570	10 521	11 202	11 352	10 991	11 117	101.1
12	Үхрийн мах	Ястай	кг	13 855	13 537	13 514	13 575	13 516	13 216	13 429	13 367	13 304	13 405	13 081	13 322	101.8
		Цул	кг	15 506	15 331	15 328	15 388	15 279	14 889	14 912	15 006	15 070	15 272	14 897	15 121	101.5
13	Адууны мах, ястай		кг	10 741	9 833	10 241	9 975	10 111	10 111	9 833	9 975	10 224	10 224	10 224	9 937	97.2
14	Ямааны мах, ястай		кг	10 488	9 000	9 000	8 643	8 643	8 643	8 643	8 643	9 000	9 000	9 000	8 986	99.8
15	Төмс, монгол		кг	963	956	930	917	869	859	813	813	772	788	840	893	106.3
16	Лууван, монгол		кг	2 953	3 093	3 030	2 467	2 348	2 321	2 198	2 198	2 263	2 280	2 367	2 518	106.4
